

БАРУУН-УРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
11 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ

Албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр: Тайлант сарын байдлаар Тамгын газраас 60 бичиг явж, 68 бичиг ирсэн байна.

Албан бичгийг удирдлагад танилцуулан цохолт хийлгэж холбогдох мэргэжилтэнд бүртгэлээр хүлээлгэн өгч, хариу барагдуулан эргэх холбоотой ажиллалаа.

Хариутай 10 албан бичиг ирснээс хугацаандаа 8 албан бичиг явсан. Хугацаа болоогүй 2 бичиг байна. Хугацаатай албан бичгийн барагдуулалт 100% байна.

Тайлант сард багийн Засаг даргын албан тодорхойлолтыг 265 иргэнд гаргаж үйлчилсэн байна.

Сумын Засаг даргын “А” захирамж-33, “Б” захирамж-2, Тамгын газрын даргын “А” тушаал-2 “Б” тушаал-8 тус тус гарсан.

Байгууллагын архиваас нийт 3 лавлагаа олгож, бүртгэл хөтөлсөн.

Төрийн үйлчилгээний оператораас 154 иргэнд лавлагаа, үйлчилээг гаргаж үйлчиллээ. Үүнээс төлбөртэй -31, төлбөргүй-123 үйлчилгээ байна.

Байгууллагын мэдээллийн цагийг мягмар гараг бүр зохион байгуулж тэмдэглэл хөтлөн, үүрэг даалгаврыг албажуулж ажилласан.


ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР:

Сумын Засаг даргын “А” захирамж-22, “Б” захирамж-3, Тамгын газрын даргын “А” тушаал-0 “Б” тушаал-15 нийт 40 шийдвэрийн хууль эрх зүйн үндэслэлийг хянаж, зөрчлийг арилган ажиллаж байна.

3 дугаар улирлын байдлаар Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд хандаж 1200 өргөдөл, гомдол ирснийг хүлээн авч, хариу мэдээлж, эргэх холбоотой ажилласан. Өргөдөл, гомдлын барагдуулалт 97%-тай байна. Өргөдөл, гомдлын улирлын тайланг гарган аймгийн Төрийн захиргаа удирдлагын хэлтэст хугацаанд хүргүүлсэн.

“Зөв хэвшил-зөв амьдрал” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хувь хүн, гэр бүл, байгууллага хамт олонд эрүүл аж төрөх дадал, зан үйлийг төлөвшүүлэх, амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй зонхилон тохиолддог халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг нэмэгдүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, олон нийт иргэдийн оролцоог сайжруулах зорилготой 2 сарын хугацаатай аян зарлаад байна.

Аянд одоогийн байдлаар 12 байгууллагын 1100 гаруй албан хаагч, сурагчид нэгдэж, дасгал хөдөлгөөнийг тогтмолжуулаад байна.



Тус сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагуудын спорт хамтлагийн арга зүйчид, биеийн тамирын багш нарын дунд нөхөрсөг уулзалт зохион байгуулж, байгууллагадаа ажлын байрны дасгалыг хийж тогтмолжуулан бие бялдрын сорил авч, үр дүнг тооцож ажиллахыг уриалсан. Уг арга хэмжээнд 31 байгууллагын 38 спорт хамтлагийн арга зүйчид оролцож бие бялдрын сорил өгч, дасгалаа заалгаж авсан. Уулзалтын зорилго нь “Зөв хэвшил-Зөв амьдрал” аянд нэгдэхийг төрийн болон төрийн бус байгууллагад уриалж, олон нийтийн оролцоог сайжруулах явдал юм.



Аймгийн Засаг даргын Тамгын газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс ирсэн удирдамж, чиглэлийн дагуу тус Тамгын газрын жилийн эцсийн тайлан, мэдээг Сүхбаатар аймгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд хугацаанд нь тайлагналаа. Үүнд:

- Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт
- Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт
- Аймгийн Засаг даргаас сумын Засаг дарга нартай байгуулсан гэрээний үүргийн биелэлт
- Сумын хөгжлийн жилийн төлөвлөгөө
- Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө
- Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилт

- Аймгийн ИТХ-ын тогтоолын хэрэгжилт
- Төрийн албан хаагчийн сургалт ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт
- ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт
- Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны гүйцэтгэл үр дүн
- Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилт
- Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ
- Шилэн дансны хэрэгжилт

Баруун-Урт сумын Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/356 тоот захирамжаар томилогдсон ажлын хэсэг тус сумын харьяа төсөвт байгууллагуудын 2022 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөгөө өгч ажиллалаа.

Хяналтыг 8 чиглэлээр, 5 хэсэг гарч 19 хүний бүрэлдэхүүнтэй хийсэн.

Хяналтаар дараах баримт бичгийг хэрэгжилтийг үзлээ.Үүнд:

- 1.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө
- 2.Тусгай захиалгат бүтээгдэхүүний хэрэгжилт
- 3.Тушаалын хууль эрх үзүй үндэслэл
- 4.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт
- 5.Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтийн тайлан
- 6.Хамран сургах тойрог
- 7.Хүүхэд хамгааллын багийн ажил
- 8.Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт

Хяналтын мөрөөр дараах зөвлөмжийг өгч ажилласан.Үүнд:

Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримтыг бичгийг бүрэн хяналтад авах, хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулах.

Засгийн газрын 2020 оны 217 тоот тогтоол, аргачлал, загвар батлах тухай ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 дугаар тушаал судлах, гүйцэтгэлийн тайлан, төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн тайлан бичих чиглэлээр тусгайлан сургалт, зөвлөгөө авах.

Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтэд нэмэлт өөрчлөлт орж 2021 оны 374 дүгээр тогтоолоор нийтдээ 5 ангилалд 46-н шалгуур үзүүлэлттэй болж өөрчлөгдсөн. Мөн ЗГ-ын 2022 оны 352 дугаар тогтоолоор нээлттэй мэдээллийг ил тод байлгах ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам батлагдсан. Тогтоолуудыг хяналтад авч, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах.

Шилэн дансны тухай хуулийг чанд мөрдөн ажиллаж, тогтоосон хугацаанд холбогдох мэдээллийг цахим хуудсанд иж бүрэн, үнэн зөв мэдээлж, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах.

Баримт бичиг боловсруулах, судалгаа, баримт, нотолгоонд тулгуурлан тайлагнах ур чадварыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн танилцуулга, мэдээллийг 10 дугаар цэцэрлэгийн багш, ажилчдад хийлээ.



ХАА-Н БОДЛОГО:

Хоршооны хөгжлийн үнэлгээг хоёр жил тутам үнэлж, цаашлаад хоршооны үйл ажиллагаанд дүгнэлт хийж түвшинд нь тохирсон бэлтгэх зорилгоор сумын дэвсгэрт үйл ажиллагаа байгаа 13 хоршоог үнэлэлээ. оролцсон оролцогчдын тайлан, үнэлгээний хүснэгт, хүлээлгэн өгсөн.



хөгжлийн зөвлөмж нутаг явуулж Үнэлгээнд бүртгэл, реп цахим санг

Сум хөгжүүлэх сангаас зээл авсан бүртгэлтэй иргэдийн мэдээлэлтэй танилцаж төлөлт хийсэн эсэх талаар e-huulga системээс орлогын мэдээлэл авч, зээлийн графикт нэмж, данс хөтлөх ажлыг хийж гүйцэтгэж байна. Мөн дотоодын үйлдвэрлэлийн тайланг орон нутгийн өмчит газраас авч нэгтгэн 2022 оны тайланг нэгтэх ажлыг хийж гүйцэтгэсэн болно.

Цагдаагийн газрын эрх бүхий албан тушаалтны хураан авсан зөвшөөрөлгүй гар дээрээс худалдан борлуулсан 3 нэр бүхий бараа бүтээгдэхүүнийг улсын орлого болгон ажиллалаа.

Тамхины хяналтын хуулийн дагуу зөвшөөрөл хүссэн 4 аж ахуй нэгжид холбогдох журмын дагуу хэмжилт хийж зөвшөөрөл олгож ажилласан болно.

Шинээр үйл ажиллагаа явуулж буй 2 аж ахуй нэгжид холбогдох журмын дагуу үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгон ажилласан байна.

Үржлийн малд, үзлэг ангилалтыг хийж, ээмэгжүүлэн бүртгэл мэдээллийн сангийн программын сургалт Хэнтий аймагт зүүн бүсийн хэмжээнд зохион байгуулагдсан. Тус сургалтад Мал эмнэлгийн улсын байцаагч оролцож программын ашиглалтын талаар арга зүйн зааварчилгаа авсан.

Аймгийн засаг даргын 2021 оны 03 сарын 19-ны өдрийн А/165 тоот захирамжийн дагуу сумын үржлийн малын 1% -д ангилалтын ажлыг хийж гүйцэтгэх ажлын хүрээнд ХХААХҮЯам, ХААИС-тай хамтран мал зүйч мэргэжилтэнд Бог малын ангилагч - шинжээчийн эрх олгох дадлага сургалтанд 5 аймгийн 56 мал зүйч нартай хамтран 10-р сарын 20-ны өдрөөс 23-ны өдрийн хугацаанд эм хонь-2713 , эм ямаа- 967, 363 хуц, 213 ухна, 8 бух нийт 4264 толгой малд ангилалт хийж анги чанарт тэнцсэн 180 хуц, 270 ухна, 359 эм хонь, 253 эм ямаа, 8 бух нийт 1070 толгой малыг цөм сүрэгт ангилан ээмэглэж, малын үржил бүртгэл, мэдээлэлийн нэгдсэн санд шивж орууллаа.

Аймгийн ХХААГазарт бэлчээрт үлийн цагаан оготной тэмцэх арга хэмжээний судалгааг 8-р багийн ажлын албатай хамтран 4 хэсэг газарт хийх хүсэлт хүргүүлсэн.Тус сумын хэмжээнд 8000 га талбайд үлийн цагаан оготно эрчимтэй тархсан судалгааг малчдын санал хүсэлтийг үндэслэн гаргасан ба 2022 онд 5000 га талбайд устгах ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна. Үүнд: Хажуу булаг 1500 га, Хөөвөр 1500 га, Энгэрийн худаг 1500 га, Өлгий 500 га талбайн судалгааг хийж зураглалыг гаргаж захиалга хүргүүлсэн.Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3,0 сая.төгрөгөөр үлийн цагаан оготно устгах бактерийн бэлдмэлийг Шим ХХК-тай гэрээ байгуулан 0,5 тн хорыг худалдан авч малчдаар дамжуулан устгалын ажлыг зохион байгуулсан.

САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Орон нутгийн болон төвлөрүүлэн захирагчийн харъяа төсөвт байгууллагуудын 2,036,634.4 мянган төгрөгийн /609/ мөнгөн зарлагын гүйлгээнд хяналт тавин баталгаажуулсан.

Төрийн сан 18н байгууллагын төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр хянан хүлээн авч, нэгтгэн сумын төсвийн гүйцэтгэлийн өр авлагын мэдээг Freebalanceпрограммд оруулсан.

Төлбөр тооцооны өдөр тутмын ажил гүйлгээний баримтуудыг бүрэн бүрдүүлж, НББ-ийн журналтай тулгаж, тухай бүр төрийн сангийн харилцах, кассын мемориалын баримтуудыг үдэж архивын нэгж үүсгэсэн.

Сум хөгжүүлэх сангийн хүрээнд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг үйл ажиллагаанд хяналт тавьж, зээлийн хүү болон үндсэн зээлийн төлөлтөд тогтмол хяналт тавин зээлийн төлөлтийн хуваарийг тухай бүр хөтлөн ажиллаж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн удирдлага мэдээллийн системийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт цэсэд ОНХС-гийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний мэдээллийг тухай бүр оруулан ажиллаж байна.

2022 оны төсвийн жилд орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зардал 804,060.8 мянган төгрөг, бусад эх үүсвэрийн орлогоор хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зардлыг 320,000.0 мянган төгрөг, малын тоо толгойн албан татвар 150,000.0 мянган төгрөг эх үүсвэртэйгээр өөрчлөн батлагдсан. /Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус XIV дүгээр хуралдааны 14 /06 тоот тогтоол/

2021 оны эхний үлдэгдэл 62,345.1 мянган төгрөг байна.

Мөрийн хөтөлбөрийн зардлаас харьяа төсөвт 12 байгууллагат 7 чиглэлээр 97,988.1 мянган төгрөгийн санхүүжилт дэмжлэг, орон нутгийн хөгжлийн сангаас 3 байгууллагат 37,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус бүрэн олгосон.

Шууд худалдан авалтын журмаар 27 ажил зохион байгуулахаас 17 ажил, харьцуулалтын аргаар 12 ажил зарлахаас 9 ажил зарлан зохион байгуулж ажилласан.

Орон нутгийн хөгжлийн сангийн ажлын гүйцэтгэл 70 хувь буюу нийт ажлын 690,903.9 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар эрх шилжиж ирсэн нийтийн эзэмшлийн орон сууцнуудын дээврийн засварын ажлын тендер нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулж тендерт 4 компани орж гүйцэтгэгчээр Хажуу ус ХХК 174,989.8 мянган төгрөгийн үнийн саналаар шалгарч гэрээ байгуулах шатандаа явагдаж байна.

ТАЦНС-ийн эцсийн хэрэглэгчдэд тусламж зөвлөгөө үзүүлэх сэдэвт цахим сургалтад 2 удаа, мөн шинэ шилэн дансны нэвтрэлтийн талаарх сургалтад төсөв төрийн сангийн мэргэжилтэн онлайнаар хамрагдсан.

Санхүүгийн CTS программ шинээр нэвтэрсэнтэй холбоотой танхимын давтан сургалтад нягтлан бодогч, нярав хамрагдсан.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Статистикийн мэдээ тайлан гаргалтанд хяналт тавин ажиллаж байна

ХОТ ТОХИЖИЛТ НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Баруун-Урт сумын ИТХ-ын ээлжит бус 14 дүгээр хурлаар Баруун-Урт сумын хог хаягдлын менежментийг сайжруулах үйл ажиллагааны 2022-2024 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулсан.

2022 оны 11 дүгээр сард нийт 87 ширхэг золбин нохойг устгаж, иргэдийн аюулгүй орчинг бүрдүүлэн ажиллаж байна.

Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 06 дугаар албан даалгавар, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 11 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангах хүрээнд албан байгууллага айл өрхийн нүхэн жорлонгийн тоог бууруулах байгаль ээлтэй хөрсөнд

нэвчдэггүй эко жорлон хэрэглэхийг уриалж ажилласан болно. Нийт 9 багийн 200 өрхөд мэдээ мэдээллийг өгч ажилласан. Мөн Баруун-Урт суманд үйл ажиллагаа явуулж буй шатахуун түгээх станцуудад хуулийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд албан тоот хүргүүлэн нийт 4 шатахуун түгээх станц хөрсөнд нэвчихгүй стандартын нүхэн жорлонтой болсон.



Намрын их цэвэрлэгээг зохион байгуулж 9 багийн 300 өрхийг хамруулсан. Албан байгууллага, аж ахуй нэгжүүдэд өөрийн байгууллагын 50 метр болон нийтийн эзэмшлийн зам талбайн хог хаягдал, шарилж, цасыг цэвэрлэх хуваарийг хүргүүлж ажиллалаа.

7 худгийн төвлөрсөн хог хаягдлын цэгийг цэгцлэх, тохижилтын ажлыг хийж эхлүүлээд байна.

9 дүгээр багийн нийтийн эзэмшлийн зам талбайд хийгдэх камержуулалт, 3 дугаар багийн нутаг дэвсгэрийн нуурын тохижилт, 7 дугаар багийн худалдааны гудамжны зураг төслийг Бат-Сүндэрлэ ХХК хийж гүйцэтгэж байна.

3 дугаар багийн нутаг дэвсгэрт зөөврийн усан сан барих тендерийг зарлаж, Хайлаас-Гарам ХХК шалгарч, тус ажлыг хийж байна. Ажлын явц 40%-тай байна.

Мөн 10 айлын дээвэр засварын тендерийг зарлаж, Молцог элс ХХК шалгарч гэрээ байгуулан ажиллаж байна.

Одкон, 27 нийтийн орон сууцны дээвэр засварын тендер зарлагдаж, Хажуу ус ХХК шалгараад байна.

МАЛ ЭМНЭЛГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор шүлхийн вакцинжуулалт хийгдэхтэй холбогдуулан 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн сумын Засаг даргын А/332 тоот захирамжийн дагуу малын их эмч, бага эмч, санитарич, туслах

ажилтан, жолооч нийт-46 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг гарч вакцинжуулалтын ажлыг хийсэн.

Мал эмнэлгийн газраас шүлхий вакцин-54.0 тун авч ариутгалын бодис ханкон-10кг, ХХХувцас-20 ш, улавч-20 ш, нүдний шил-20ш, ААН-ийн эмч нарт хуваарилан өгч ажиллаа. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад үхэр-36985, тугал-13559, гахай-103, хот айл-722, нийт-50647 толгой мал тарилгад хамрагдсан.

Тарилгын зарцуулалтад вакцин-101294 мт, хэвийн хорогдол-253, зарцуулан-50647 тун, үхэр-36985, тугал-13559 гахай-103, нийт-50647 толгой малд хийж гүйцэтгэлээ. Тарилгын хоосон шил-509 ширхэгийг, малын эмч нараас хүлээн авч, МЭГазарт тушаан, үлдэгдэл-3.1 тун вакциныг эмийн няравт хүлээлгэн өгсөн. 2022 оны 11 дүгээр сарын 11-нээс 45 хоногийн хугацаатай Мал, мах-2022 арга хэмжээнд Улсын байцаагч А.Доржсүрэн, тархвар зүйч Д.Бямбасүрэн, Мал эмнэлгийн газрын эмч, мэргэжилтэн нартай болон Цагдаагийн газартай хамтран гарал үүслийн гэрчилгээнд хяналт тавин цагдаагийн хяналтын баруун постод 24 цагаар гарч үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

Баруун-Урт сумын залуучууд шинэлэг санаа, бүтээлч сэтгэлгээгээ уралдуулж, өөрсдийн үзэл бодлоо илэрхийлэн, дуу хоолойгоо нийгэмд түгээн, санал бодлоо солилцож нэг өдрийг үеийн залуучуудтайгаа чуулсан.

Өдөрлөгийн зочин илтгэгчээр Сүхбаатар аймгийн Засаг дарга М.Идэрбат, Баруун-Урт сумын Засаг дарга Ж.Жавхаатөгс, Монгол банкны захирал Ц.Мөнхбаяр,



Сүхбаатар аймгийн залуучуудын холбооны дарга Ц.Өлзийжаргал, Гэртээ гэрэл асаая II хөтөлбөрийн сургагч багш Д.Нямсүрэн, Ө.Жавзандулам нар оролцсон. Мөн урилгаар УИХ-ын гишүүн Ж. Батсуурь оролцож залуучуудад сонирхолтой мэдээллийг өгсөн. Уг өдөрлөгийн сургалтыг "ИЛТГЭХ ИНДРИЙН ИРЭЭДҮЙ" ТББ-ын сургагч багш Д.Хүрэлбаатар түүний сургалтын баг удирдан явуулсан.

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын аварга шалгаруулах Адуучин тэмцээн 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр Баяншарга уулын бэлд болж өнгөрлөө. Баруун-Урт сумын ЗДТГ-ийн 8 дугаар багийн ажлын албанаас санаачлан сумын ИТХ-тай хамтран анхлан зохион байгууллаа. Монгол адууны уламжлал өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, зан заншлаа

хадгалан хамгаалж, хөгжүүлэх, нийтэд сурталчлах, адуучин залуусаа алдаршуулах, авхаалж самбааг шалгах, ур ухааныг залуустаа өвлүүлэн үлдээх, монгол адуучдын эв хав, эрэмгий байдал Сүхбаатар нутгийнхаа онцлог болсон адуу эдлэх соёл, түгээн дэлгэрүүлэх зорилгоор адуучин тэмцээнийг зохион байгуулсан бөгөөд адуун сүргийн тоо толгой, болон сум орон нутгийн хөдөө аж ахуй, авч хэрэгжүүлж байгаа төрийн бодлого мөн цаашид өв соёлоо хэрхэн сурталчилан таниулах талаар ИТХ-ын дарга, сум, багийн Засаг дарга нар ард иргэдтэйгээ ярилцлаа.

Тэмцээнд нийт 50 гаруй моринд эрэмгий залуус оролцлоо. Тэмцээний үеэр явган морьтой шургаа, уурга шүүрэх, эмнэг булгиулах, хос морьтон зэрэг 5 төрлөөр оролцож, хурд хүч авхаалж самбайгаа сорьсон.

Баруун-Урт сумын аймаг, сумын сайн малчдаас жил бүр 10 толгой бог мал авч багийн залуу болон зорилтот бүлгийн малчин өрхийг сонгон малжуулдаг уламжлалтай. Энэ жилийн хувьд 7 малчин өрхөд нийт 70 толгой малыг хүлээлгэн өглөө. Мал маллах хүсэл эрмэлзэлтэй залуусыг малжуулах, монголын уламжлалт мал аж ахуйг хөгжүүлэх зорилго бүхий "Малжуулах төсөл" 2013 оноос хойш одоог хүртэл үр дүнтэй хэрэгжиж байна.



Монголын Оюун Ухааны Академийн Сүхбаатар салбарт багийн бяцхан иргэдийн төлөөлөл болох 10 хүүхдийг эцэг эхийн хамт аялуулж, үйл ажиллагаатай нь танилцуулан Оюуны спортоор хичээллэх, хүсэл сонирхлыг нь төрүүлэх "Спорт аяга өрөлт" сургалтыг зохион байгууллаа.



Баруун-Урт сумын ахмадын шугам бүжгийн аварга багийн бүжигчдээр ажлын байранд хэрэгжүүлэх



боломжтой, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх ач холбогдолтой, нийтийн 3 төрлийн бүжгийг иргэдэд үйлчлэх тасгийн хамт олон болон мандарваа цэцэрлэгийн албан хаагчдад зохион байгууллаа.Нийт 50 албан хаагч хамрагдсан.

Тайлан нэгтгэсэн:

Хууль эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн:

А.Өлзийжаргал